

ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2019 оны 3 сарын 27

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгон, төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн 2018 оны жилийн эцсийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлын хүрээнд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын дунд хугацааны стратеги/, төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг 2018 оны байдлаар гаргуулан авч үнэлгээг хийв.

3.1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилт.

Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн үнэлгээг 59 зорилтын хүрээнд хийлээ.

Бодлогын зорилтоор нь авч үзвэл Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд 12 зорилтын биелэлт 76.6 хувь, Геологийн салбарын хүрээний 15 зорилтын биелэлт 96.0 хувь, Олборлох салбарын хүрээнд хүрээний 7 зорилтын биелэлт 52.8 хувь, Боловсруулах салбарын хүрээний 5 зорилтын 28 хувь, Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээний 2 зорилтын биелэлт 100.0 хувь, Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээний 5 зорилтын биелэлт 58.0 хувь, Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээний 13 зорилтын биелэлт 74.5.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 59 арга хэмжээний биелэлтийг 73.3 хувьтай дүгнэлээ.

**ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

/2019 оны 3 дугаар сарын байдлаар/

Зорилт	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
		100	70	40	0	/-/	
1. Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд	12	7	2	2	1	-	76.6
2. Геологийн салбарын хүрээнд	15	13	2	-	-	-	96.0
3. Олборлох салбарын хүрээнд	7		3	4	-	-	52.8
4. Боловсруулах салбарын хүрээнд	5	-	2	-	3	-	28.0
5. Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд	2	2	-	-	-	-	100.0
6. Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд	5	1	1	3	-	-	58.0
7. Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээнд	13	6	2	2	1	2	74.5
Дүн	59	29	12	11	5	2	73.3

3.2. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт.

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг баталсан. Тус бодлогыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 2015-2020 онд/I үе шат/, 2020-2025 он /II үе шат/, 2025-2030 он /III үе шат/-уудад хэрэгжих ба Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2015-2020/-ийг баталсан байна.

Тус бодлогыг үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ байсан бөгөөд яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолын дагуу хүнд аж үйлдвэрийн асуудал нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд, хөнгөн үйлдвэрийн асуудал нь Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, зарим бусад асуудал нь Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хамаарч байна.

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЯВЦ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

/2019 оны 3 дугаар сарын байдлаар/

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
		100	70	40	0	/-/	
1. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;	3		1	2			50,0

2. Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах;	3			3			40,0
3. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх;	9/6-УУХҮЯ-нд хамаарна			6			40,0
4. Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	2			1		1	40,0
5. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;	2/УУХҮЯ-нд хамаарахгүй						/-/
6. Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.	2/1			1			40,0
Дүн	21		1	13		1	39,3

Дунд хугацааны стратегид тусгагдсан 21 арга хэмжээний 15 нь УУХҮЯ-ны эрхлэх асуудалд, 6 арга хэмжээ нь бусад байгууллагад тус тус хамаарч байна.

Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэхээр батлагдсан дунд хугацааны стратеги-д зорилт, арга хэмжээний суурь үзүүлэлт, хүрэх түвшин, шалгуурыг тусгаагүй, бодлого, стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулаагүй, төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх ажил яамдын бүтцийн өөрчлөлтөөр эзэнгүйдэж орхигдсон байна.

Дээрх байдал нь бодлогын үр дүн, тухайн жилийн явцыг үнэлэхэд бэрхшээлтэй байна. Уг бодлого, стратегийн 2018 оны ажлын гүйцэтгэлд 39,3 хувийн үнэлгээг өгөв.

3.4. Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын хэрэгжилт.

Улсын Их Хурлын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”

батлагдсан бөгөөд бодлогын баримт бичгийн хугацаа дууссантай холбогдуулан газрын тосны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн төсөл, холбогдох мэдээллийг яам, агентлаг, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран боловсруулсан байна.

Бодлогын баримт бичиг боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/101 дүгээр тушаалаар байгуулж, ажлын хэсгийн хүрээнд төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэж, бодлогын баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулжээ. Мөн ажлын хэсгийн хүрээнд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн бодлогын төслийн нөлөөллийн шинжилгээ, төлөвлөгөөний төсөл болон бусад мэдээлэл судалгаа, нөхцөл байдлын шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

Бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2018 оны 6 сарын 6-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)” батлагдсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.5.-д *Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ* гэж заасан. Салбарын бодлого, хэрэгжилт хариуцсан нэгж нь Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулаагүй, уг бодлогод тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх суурь түвшин, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй байгаа нь бодлогын зорилт, хүрсэн үр дүнд үнэлгээ өгч, дүгнэхэд бэрхшээлтэй байв.

Бодлогод газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх; газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх; газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах; салбарын хүний нөөц, ажиллах хүч бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх; газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих; газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх үндсэн 6 зорилтын хүрээнд 32 үйл ажиллагааг 2018-2021 он, 2022-2027 он гэсэн 2 үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан байна.

**ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР 2027 ОН
ХҮРТЭЛ БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ЯВЦ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

/2019 оны 3 дугаар сарын байдлаар/

Зорилт	Үйл ажиллагаа ны тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
		100	70	40	0	/-/	
1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх	7			7			40,0

2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	7			6		1	40,0
3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	7		4	3			57,1
4. Салбарын хүний нөөц, ажиллах хүч бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх	3				3		0,0
5. Газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих	4	1		3			55,0
6. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх	4					4	/-/
Дүн	32	1	4	19	3	4	40,7

Бодлогын баримт бичгийн Дөрөв-т бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт батлагдсан боловч эдгээр шалгуур нь 2022, 2027 онуудад хүрэх түвшингээр хязгаарлагдаж байх тул жил бүрийн явцын үр дүнг тооцох боломжгүй байна.

Дөрөв. Дүгнэлт.

- Салбарт хэрэгжиж буй төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, газрын тосны салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ заалтыг хэрэгжүүлээгүй, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах ажил орхигдуулсан гэж үзэх үндэслэлтэй байна.
- Бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөгүй байгаагаас бодлогын хэрэгжилт, явцыг бодитой үнэлж дүгнэхэд бэрхшээлтэй байна. Энэ нь бодлогод тусгагдсан үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат, суурь үзүүлэлт, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтгүй байгаагаас шалтгаалж байна.
- Газрын тосны салбарт баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, яамны жилийн төлөвлөгөөний хүрээнд биелэлт гаргаж байгаа нь бодлогын баримт бичгийн явцын үнэлгээ хийх, үр дүнг тооцох, санал зөвлөмж өгөхөд учир дутагдалтай байна.
- Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги-д тусгагдсан зорилт, арга хэмжээний суурь үзүүлэлт тодорхойгүй, хүрэх түвшингүй, шалгуурыг тогтоогоогүй, хариуцан хэрэгжүүлэх байгууллага тодорхой бус байгаа нь үнэлгээ хийж дүгнэхэд бэрхшээлтэй байна.
- Аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратгийн 4.3.2-т газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах арга хэмжээг баталсан нь Газрын тосны салбарт баримтлах бодлогод тусгагдсан 2.2.2-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаатай давхцалтай байна. Энэ нь бодлогыг

хэрэгжүүлэх явцад тодорхойгүй байдал бий болох, давхардал хийдэл гарах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзлээ.

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийг тайлагнахдаа биелэлт болон хэрэгжүүлэх арга хэмжээ нь авцалдаагүй, зорилт 3.7.9-д биелэлт гаргаагүй, 3.7.13-д хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, 3.4.5-д заасан арга хэмжээг орхиж тайлагнасан.
- Боловсруулах салбарын бодлогын хүрээнд 5 зорилт арга хэмжээний биелэлт хангалтгүй эдгээрээс 3 арга хэмжээ 0 үнэлгээтэй.

Тав. Санал, зөвлөмж.

- Бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг холбогдох хууль, тогтоомжийн дагуу даруй боловсруулж батлуулах шаардлагатай байна. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого 2014 онд, Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2015 онд, Газрын тосны салбарт баримтлах бодлого 2018 онд тус тус батлагдсан ба хэрэгжилт хариуцсан нэгж, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох нөхцөл бүрдсэн байна.
- Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлогыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд боловсруулсан бөгөөд бодлогын баримт бичиг батлагдсан даруйд бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.
- Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, стратегийг хариуцах байгууллагыг тодорхой болгох, төлөвлөгөөг батлах, шалгуурыг нарийвчлан тогтоох шаардлагатай.
- Яамны зүгээс салбарт хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хийх, хэрэгжилтийг газар дээр нь нягтлан шалгах, тайланг хэлэлцэх түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлого, Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайланг тус тус хавсаргав.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2019 он